

## Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах чиглэлээр: Телевизүүдийн дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдал ( 2024 он )

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх телевиз нь өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлэг зэргийг дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах төлөвлөгөөг үе шаттайгаар боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.4-т заасан хадмал тайлбар, дохионы хэл бүхий нэвтрүүлгийн хувь хэмжээг тодорхойлох чиг үүргийн дагуу Монгол Улсад хамрах хүрээтэй телевизүүдэд мэдээ, мэдээллийн хөтөлбөр, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөөг өөрийн боломжид тулгуурлан редакцын бодлогын хүрээнд төлөвлөж төлөвлөгөөний дагуу гаргах үүргийг хүлээлгэсэн болно. Энэ нь дохионы хэлний хэлмэрчийн олдоц хязгаарлагдмал байдлыг харгалзан шат дараатай авч буй арга хэмжээний нэг юм.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад хамрах хүрээтэй Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18, орон нутгийн 3 телевиз болон хөтөлбөртөө цаг үеийн мэдээ, мэдээлэл, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгүүд тусган нэвтрүүлдэг арилжааны 26, нийт 47 телевиз дохионы хэлтэй, эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх үүрэг хүлээж байна. Харин Монгол Улсад хамрах хүрээтэй боловч спорт, кино, теле-худалдаа зэрэг төрөлжсөн хөтөлбөртэй, хөтөлбөрт нь мэдээ, мэдээлэл, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлэг байхгүй 13 арилжааны телевизийн хувьд дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх үүрэг хүлээлгээгүй болно.

Энэхүү тайлангаар телевизүүдийн хөтөлбөрийн 2024 оны хяналт, мониторингийн дүнгээс телевизүүд мэдээ мэдээлэл, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэл, хадмал тайлбартай хэрхэн нэвтрүүлсэн талаарх дүн мэдээг мөн 2024 оны 1-р улиралд телевизүүд тухайн онд нэвтрүүлэх дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай өөрсдийн нэвтрүүлгийг бүтэн жилээр төлөвлөн ирүүлсэн нь хувь хэмжээнд хүрсэн эсэх талаар нэгтгэн гаргаж байна.



2024 оны байдлаар МҮОНРТ-ийн 5 телевиз, өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, Монгол Улсад хамрах хүрээтэй 23 телевиз, мөн үүрэг хүлээгээгүй боловч телевизийн редакцын хүрээнд 8 телевиз буюу нийт 54 телевизээр **8480** цагийн дохионы хэлтэй нэвтрүүлэг нэвтрүүлжээ. Нийт цагийн **67.7%-д 29** телевизээр **мэдээ, мэдээлэл, 8.5%-д 16** телевизээр **танин мэдэхүйн нэвтрүүлэг**, харин **1.33%-д нь 8** телевизээр **хүүхдийн** нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн. Нийт **49** телевиз **2584** цагийн хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн ба нийт цагийн **51%-д 21** телевизээр **танин мэдэхүйн** нэвтрүүлэг, **0.37%-д 3** телевизээр **мэдээ, мэдээллийн** нэвтрүүлэг, **7.7%-д 7** телевиз **хүүхдийн** нэвтрүүлгийг тус тус нэвтрүүлсэн байна.

Өнгөрсөн онтой харьцуулан харахад дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлэг нэвтрүүлсэн телевиз 1-р нэмэгдсэн, хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевиз 3-аар нэмэгдсэн байна. Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн нийт цагийн хувьд 965 цагаар буурсан, бичгэн тайлбартай нэвтрүүлэг 925 цагаар нэмэгджээ.

2024 он нь Монгол Улсын Их хурлын болон Аймаг нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгууль болсон онцлогтой жил байлаа. Монгол Улсын Их хурлын

Сонгуулийн тухай хуулийн 46.27-д “Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал, тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байж болно” гэж заасны дагуу нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн бэлтгэн телевизүүдээр гаргасан сонгуулийн сурталчилгаа болон телевизүүдийн өөрсдийн редакцадаа бэлтгэн хүргэсэн сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгүүдийн **20.74%** нь дохионы хэлтэй, **38.44%** нь бичгэн тайлбартай байна.

**2024 онд 54 телевизээр нэвтрүүлсэн дохионы хэл бичгэн тайлбартай  
нэвтрүүлгийн төрөл жанр /хувь/**



Тайлбар: Дохионы хэлтэй нэвтрүүлсэн нэвтрүүлгийн хувь хэмжээг харахад мэдээ мэдээллийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн байдал 67.7%, нийгэм, улс төрийн сэдэвтэй нэвтрүүлгийг

20.47% байгаа бол бичгэн тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн хувьд танин мэдэхүйн нэвтрүүлэг хамгийн их буюу 50.60% нийгэм, улс төрийн сэдэвтэй нэвтрүүлэг 38.13%-тай нэвтрүүлжээ.

Монгол Улсад хамрах хүрээтэй Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18, орон нутгийн 3 телевиз болон хөтөлбөртөө цаг үеийн мэдээ, мэдээлэл, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгүүд тусган нэвтрүүлдэг арилжааны 26, нийт 47 телевиз дохионы хэлтэй, эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх үүрэг хүлээж байна. 2024 онд тус телевизүүдээс ирүүлсэн төлөвлөлтийн дагуу хэрэгжилтийг харахад Өргөн нэвтрүүлгийн 5 телевиз, Арилжааны 16 телевиз нь ирүүлсэн төлөвлөлтөө хангасан үзүүлэлттэй байна. Иймд цаашид телевизүүдийн тухайн жилийн төлөвлөлтөд тус Хорооноос илүү анхаарч бодит зөв төлөвлөлт гаргахад хамтран ажиллах шаардлагатай гэж үзлээ.

### Дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлсэн нийт нэвтрүүлгүүд

2024 оны байдлаар

|                                                 | Нэвтрүүлгийн төрөл                                                                            | Телевизийн тоо                                                                   | Нийт (цаг:мин:сек)                                                                                                          | Нийт нэвтрүүлэгт эзлэх хувь                                                                                  |
|-------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------|
| Дохионы хэлний хэлмэртэй нэвтрүүлсэн нэвтрүүлэг | Мэдээ мэдээллийн нэвтрүүлэг                                                                   | 29                                                                               | 5741:10:27                                                                                                                  | 67.70%                                                                                                       |
|                                                 | Хүүхдийн нэвтрүүлэг                                                                           | 8                                                                                | 112:26:12                                                                                                                   | 1.33%                                                                                                        |
|                                                 | Танин мэдэхүйн нэвтрүүлэг                                                                     | 17                                                                               | 725:39:27                                                                                                                   | 8.35%                                                                                                        |
|                                                 | Бусад нэвтрүүлэг (кино, нийгэм, улс төр, соёл урлаг, спорт, зар сурталчилгаа, цэнгээнт,шашин) | Кино-6<br>Нийгэм улс төр-44<br>Соёл урлаг-4<br>Спорт-3<br>Цэнгээнт-3<br>Шашин-2  | Кино-59:46:03<br>Нийгэм улс төр-1735:42:04<br>Соёл урлаг-30:37:38<br>Спорт- 63:08:52<br>Цэнгээнт-09:54:45<br>Шашин-02:12:03 | Кино-0.70%<br>Нийгэм улс төр- <b>20.47%</b><br>Соёл урлаг-0.36%<br>Цэнгээнт-0.12%<br>Шашин-0.03%             |
|                                                 | <b>НИЙТ</b>                                                                                   | <b>54 ТВ</b>                                                                     | <b>8480:37:31</b>                                                                                                           |                                                                                                              |
| Хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлэг        | Мэдээ мэдээллийн нэвтрүүлэг                                                                   | 3                                                                                | 09:29:26                                                                                                                    | 0.37%                                                                                                        |
|                                                 | Хүүхдийн нэвтрүүлэг                                                                           | 7                                                                                | 200:53:18                                                                                                                   | 7.77%                                                                                                        |
|                                                 | Танин мэдэхүйн нэвтрүүлэг                                                                     | 21                                                                               | 1307:55:22                                                                                                                  | 50.60%                                                                                                       |
|                                                 | Бусад нэвтрүүлэг (кино, нийгэм, улс төр, соёл урлаг, спорт, зар сурталчилгаа, цэнгээнт,шашин) | Кино-1<br>Нийгэм улс төр-43<br>Соёл урлаг-1<br>Спорт-3<br>Цэнгээнт-17<br>Шашин-2 | Кино-03:01:34<br>Нийгэм улс төр-985:39:56<br>Соёл урлаг-03:08:50<br>Спорт-03:26:43<br>Цэнгээнт-25:57:13<br>Шашин-45:15:08   | Кино-0.12%<br>Нийгэм улс төр- <b>38.13%</b><br>Соёл урлаг-0.12%<br>Спорт-0.13%<br>Цэнгээнт-1%<br>Шашин-1.75% |
|                                                 | <b>НИЙТ</b>                                                                                   | <b>49 ТВ</b>                                                                     | <b>2584:56:50</b>                                                                                                           |                                                                                                              |


## 1. Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн нэвтрүүлгийн тайлан (Телевиз тус бүрээр)

1.1 Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн телевизүүд

2024 оны байдлаар

| №                             | Телевизийн нэр                       | Дохионы хэлтэй нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн цаг |
|-------------------------------|--------------------------------------|--------------------------------------------------------------|
| Үндэсний олон нийтийн телевиз |                                      |                                                              |
| 1.                            | MNB                                  | 404:31:21                                                    |
| 2.                            | MNB Монголын мэдээ                   | 627:16:55                                                    |
| 3.                            | MNB Спорт                            | 6:00:48                                                      |
| Өргөн нэвтрүүлгийн телевиз    |                                      |                                                              |
| 4.                            | C1                                   | 295:37:13                                                    |
| 5.                            | NTV                                  | 588:24:35                                                    |
| 6.                            | SBN                                  | 72:21:48                                                     |
| 7.                            | UBS                                  | 534:50:42                                                    |
| 8.                            | Ийгл ньюс                            | 629:15:04                                                    |
| 9.                            | Монгол HD                            | 219:30:06                                                    |
| 10.                           | Сүлд                                 | 40:21:56                                                     |
| 11.                           | TB5                                  | 21:19:14                                                     |
| 12.                           | TB8                                  | 269:58:45                                                    |
| 13.                           | TB9                                  | 214:00:16                                                    |
| 14.                           | Тэнгэр ТВ                            | 464:13:10                                                    |
| Арилжааны телевиз             |                                      |                                                              |
| 15.                           | Channel 11                           | 105:18:17                                                    |
| 16.                           | National times news                  | 173:55:33                                                    |
| 17.                           | Volume Plus                          | 9:14:42                                                      |
| 18.                           | Авто ТВ                              | 95:25:47                                                     |
| 19.                           | Глобал ТВ                            | 82:38:32                                                     |
| 20.                           | Лайв ТВ                              | 171:44:21                                                    |
| 21.                           | Лайк ТВ                              | 32:36:41                                                     |
| 22.                           | Мянгат малчин ТВ                     | 67:36:50                                                     |
| 23.                           | ОНТВ                                 | 0:52:18                                                      |
| 24.                           | Парламент                            | 45:02:03                                                     |
| 25.                           | Суваг 1                              | 123:18:55                                                    |
| 26.                           | Талын Монгол                         | 80:01:45                                                     |
| 27.                           | TB2                                  | 241:44:15                                                    |
| 28.                           | TB6                                  | 109:03:17                                                    |
| 29.                           | Хөгжил ТВ                            | 14:55:18                                                     |
|                               | <b>Нийт цаг</b>                      | <b>5741:10:27</b>                                            |
|                               | <b>Нийт дохионы хэлд харьцуулсан</b> | <b>67.70%</b>                                                |

Дээрх нэр бүхий 28 телевиз өдөр тутмын мэдээллийн хөтөлбөрөө тодорхой хэмжээнд дохионы хэлтэй нэвтрүүлсэн байна. Харин өргөн нэвтрүүлгийн 18 телевизээс 11 телевиз мэдээ, мэдээллийн хөтөлбөрөө дохионы хэлтэй бэлтгэн нэвтрүүлжээ.



## 1.2 Танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн телевизүүд


2024 оны байдлаар

| №                                 | Телевизийн нэр                       | Дохионы хэлтэй нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг |
|-----------------------------------|--------------------------------------|------------------------------------------------------------|
| 1.                                | MNB Гэр бүл                          | 1:20:22                                                    |
| 2.                                | MNB Монголын мэдээ                   | 1:20:26                                                    |
| <b>Өргөн нэвтрүүлгийн телевиз</b> |                                      |                                                            |
| 3.                                | TB5                                  | 195:08:55                                                  |
| <b>Арилжааны телевиз</b>          |                                      |                                                            |
| 4.                                | Movie Max                            | 27:22:57                                                   |
| 5.                                | National times news                  | 63:00:51                                                   |
| 6.                                | News Channel                         | 15:31:21                                                   |
| 7.                                | Гандан ТВ                            | 33:47:05                                                   |
| 8.                                | Их Засаг                             | 159:50:11                                                  |
| 9.                                | Лайк ТВ                              | 92:11:37                                                   |
| 10.                               | ОНТВ                                 | 52:47:56                                                   |
| 11.                               | Парламент                            | 0:09:36                                                    |
| 12.                               | Соён гэгээрүүлэгч                    | 9:51:02                                                    |
| 13.                               | Суваг 7                              | 8:33:08                                                    |
| 14.                               | Талын Монгол                         | 2:18:54                                                    |
| 15.                               | ТВ6                                  | 34:56:53                                                   |
| 16.                               | Хөгжил ТВ                            | 25:15:26                                                   |
| 17.                               | Цахим Монгол                         | 2:12:47                                                    |
|                                   | <b>Нийт цаг</b>                      | <b>725:39:27</b>                                           |
|                                   | <b>Нийт дохионы хэлд харьцуулсан</b> | <b>8.56%</b>                                               |

Дээрх телевизүүдээс Лайк телевиз эрүүл мэндийн зөвлөгөө зөвлөмжийн нэвтрүүлгээ тогтмол дохионы хэлтэй нэвтрүүлдэг бөгөөд Талын монгол, TV5 телевизүүд нь Түүх, соёл, зан заншлын нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлж байна.

Мөн 2024 оны 09-р сараас эхлэн ОНТВ нь “Дохионы хэл сурцгаая” нэртэй танин мэдэхүйн боловсрол олгох нэвтрүүлэг нэвтрүүлж байгаа нь онцлох нэвтрүүлэг болж байна.

Танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлний цагийг 2021-2024 оноор харьцуулбал 58 цагаар өссөн үзүүлэлтэй байна.




### 1.3 Хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн телевизүүд

2024 оны байдлаар


| №                                 | Телевизийн нэр                       | Дохионы хэлтэй нэвтрүүлсэн хүүхдийн нэвтрүүлгийн цаг |
|-----------------------------------|--------------------------------------|------------------------------------------------------|
| 1.                                | MNB                                  | 0:49:23                                              |
| <b>Өргөн нэвтрүүлгийн телевиз</b> |                                      |                                                      |
| 2.                                | ETV                                  | 28:48:32                                             |
| 3.                                | Стар ТВ                              | 1:14:30                                              |
| 4.                                | TB5                                  | 48:54:42                                             |
| 5.                                | TB8                                  | 2:38:49                                              |
| <b>Арилжааны телевиз</b>          |                                      |                                                      |
| 6.                                | Dream                                | 0:39:27                                              |
| 7.                                | Movie Max                            | 15:19:40                                             |
| 8.                                | Масс ТВ                              | 14:01:09                                             |
|                                   | <b>Нийт цаг</b>                      | <b>112:26:12</b>                                     |
|                                   | <b>Нийт дохионы хэлд харьцуулсан</b> | <b>1.33%</b>                                         |

2024 онд **112** цагийн хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн байна. Масс, Movie max телевизүүд нь хүүхдийн нэвтрүүлэгтэй болж дохионы хэлмэрчтэйгээр нэвтрүүлж эхэлжээ.

Хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлний цагийг 2021-2024 оноор харьцуулан гаргахад дохионы хэлтэй нэвтрүүлсэн цаг өнгөрсөн оноос 32 цагаар өссөн үзүүлэлттэй байна.



#### 1.4 Бусад нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн байдал




## 2. Телевизүүдээр нэвтрүүлсэн хадмал тайлбартай нэвтрүүлгийн тайлан

### 2.1 Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевизүүд

| №                                 | Телевизийн нэр                            | Дохионы хэлтэй нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн цаг |
|-----------------------------------|-------------------------------------------|--------------------------------------------------------------|
| <b>Өргөн нэвтрүүлгийн телевиз</b> |                                           |                                                              |
| 1.                                | Малчин                                    | 8:09:04                                                      |
| 2.                                | ТМ                                        | 0:27:11                                                      |
| 3.                                | 25-р суваг                                | 0:53:11                                                      |
|                                   | <b>Нийт цаг</b>                           | <b>9:29:26</b>                                               |
|                                   | <b>Нийт бичгэн тайлбартай харьцуулсан</b> | <b>0.37%</b>                                                 |

Мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн хувьд ихэнх телевизүүд дохионы хэлний хэлмэрчтэй гаргаж байгаа тул хадмал тайлбартай мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг нэвтрүүлж байгаа телевизийн тоо, хугацаа бага болно.

Мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг бичгэн тайлбартай нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлний цагийг 2023-2024 оноор доор харьцуулсан графикаас харахад 2023 оноос эхлэн хадмал тайлбартай гаргасан мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн цаг багасаж, дохионы хэлтэй нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн цаг ихэссэн харагдаж байна.



## 2.2 Танин мэдэхүйн нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевизүүд

*2024 оны байдлаар*


| №                                 | Телевизийн нэр | Дохионы хэлтэй нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг |
|-----------------------------------|----------------|------------------------------------------------------------|
| <b>Өргөн нэвтрүүлгийн телевиз</b> |                |                                                            |
| 1.                                | Централ        | 284:41:17                                                  |
| 2.                                | Боловсрол      | 328:58:42                                                  |
| 3.                                | ТВ5            | 217:56:29                                                  |
| 4.                                | Стар           | 149:16:52                                                  |
| 5.                                | Тэнгэр ТВ      | 60:23:45                                                   |
| 6.                                | Монгол HD      | 57:50:31                                                   |
| 7.                                | Ийгл ньюс      | 18:59:23                                                   |
| 8.                                | Малчин ТВ      | 8:47:14                                                    |
| 9.                                | UBS            | 0:04:08                                                    |
| <b>Арилжааны телевиз</b>          |                |                                                            |



|     |                                           |                   |
|-----|-------------------------------------------|-------------------|
| 10. | Мянгат Малчин ТВ                          | 51:23:09          |
| 11. | ОНТВ                                      | 52:47:56          |
| 12. | Movie Max                                 | 34:33:46          |
| 13. | Volume Plus                               | 13:14:26          |
| 14. | Dream TV                                  | 8:51:26           |
| 15. | National times news                       | 7:36:39           |
| 16. | Суваг 1                                   | 6:22:16           |
| 17. | Авто ТВ                                   | 4:08:57           |
| 18. | ТВ3                                       | 0:59:10           |
| 19. | Их Засаг                                  | 0:44:57           |
| 20. | Гандан ТВ                                 | 0:11:03           |
| 21. | Хөх Монгол                                | 0:03:16           |
|     | Нийт цаг                                  | <b>1307:55:22</b> |
|     | <b>Нийт битгэн тайлбартай харьцуулсан</b> | <b>50.60%</b>     |

Телевизүүд танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй гаргахаас илүүтэйгээр хадмал тайлбартай гаргаж байгаа нь дээрх хувь хэмжээнээс харагдаж байна. Дохионы хэлтэй нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлгийн хувь 8.56 байсан бол хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн хувь 50.60 байна.

Мөн доорх бичгэн тайлбартай нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлний цагийг 2021-2024 оноор харьцуулан гаргахад хадмал тайлбартай нэвтрүүлсэн цаг өнгөрсөн оноос 900 цагаар өсжээ.



### 2.3 Хүүхдийн нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевизүүд


*2024 оны хагас жилийн байдлаар*

| №                                 | Телевизийн нэр      | Дохионы хэлтэй нэвтрүүлсэн хүүхдийн нэвтрүүлгийн цаг |
|-----------------------------------|---------------------|------------------------------------------------------|
|                                   | MNB                 | 0:49:23                                              |
| <b>Өргөн нэвтрүүлгийн телевиз</b> |                     |                                                      |
| 9.                                | C1                  | 29:25:26                                             |
| 10.                               | Монгол HD           | 25:38:21                                             |
| 11.                               | Боловсрол суваг     | 0:06:38                                              |
| <b>Арилжааны телевиз</b>          |                     |                                                      |
| 12.                               | National times news | 65:16:10                                             |
| 13.                               | Dream TV            | 60:01:58                                             |
| 14.                               | Мянгат Малчин ТВ    | 19:35:22                                             |


|                                           |                  |
|-------------------------------------------|------------------|
| <b>Нийт цаг</b>                           | <b>200:53:18</b> |
| <b>Нийт бичгэн тайлбартай харьцуулсан</b> | <b>7.77%</b>     |

Хүүхдийн нэвтрүүлгийн хувьд телевизүүд дохионы хэлтэй гаргахаас илүүтэйгээр хадмал тайлбартай гаргаж байна. Дохионы хэлтэй нэвтрүүлсэн хүүхдийн нэвтрүүлгийн хувь 1.33 байсан бол хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн хувь 7.77 байна. Мөн хүүхдийн нэвтрүүлгээр төрөлжсөн Дрийм телевиз нь “content review”, “францаар ярьж сурцгаая” нэвтрүүлгүүдийг тухайн жилд шинээр бүтээн бичгэн тайлбартайгаар хүүхдүүдэд хүргэж эхэлсэн.

Мөн доорх хадмал тайлбартай нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлний цагийг 2023-2024 оноор доор харьцуулан гаргахад хадмал тайлбартай нэвтрүүлсэн цаг өнгөрсөн оноос 80 цагаар өссөн үзүүлэлттэй байна.



#### 2.4 Бусад нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн байдал



Дээрх хадмал тайлбартай нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн бичгэн тайлбартай цагийг 2023-2024 оноор харьцуулбал хадмал тайлбартай нэвтрүүлсэн нийгэм, улс төрийн нэвтрүүлэг өнгөрсөн оноос 70 цагаар өсжээ.

### **ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО**